БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗӨСТ-ИЙН
ДАРГА Н.МӨНГӨНЦЭЦЭГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2023 оны 05-р сарын 12-ны өдөр Дугаар: Мандалговь хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 460 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулах төсөл арга хэмжээний жагсаалтын II.2.4.1-д тусгагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалтын хүрээнд 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/16 дугаар тушаалаар батлагдсан. Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны 04801-А/276/2023 дугаар захирамжаар Сайнцагаан сумын 7 дугаар баг, Г.Чагдаржавын гудамж-5, 508 тоот хаягт олгосон, 4809015763 нэгж талбарын дугаартай газар олголтыг тус тус үндэслэв.
2	Барилга байгууламжийн байршил	Дундговь аймаг, Сайнцагаан сум 7-р баг;
3	Зориулалт, хүчин чадал	Зоонозын өвчин судлалын төвийн барилга
4	Барилгын үндсэн бүтээц, материал	Цутгамал төмөр бетон каркас;
5	Инженерийн шугам сүлжээ, түүний хангах эх үүсвэр	Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбох; Шаардлагатай тохиолдолд өөрийн эх үүсвэрээр (цахилгаан) хангах зураг төсөв боловсруулан холбогдох байгууллагуудаар зөвшилцөн батлуулах шаардлагатай;
6	Зураг төслийн бүрдэл	<u>Баримт бичгийн иж бүрдэл:</u> - Эх загвар зургийн шатанд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газартай зөвшөөрөлцөх - Инженер геологийн дүгнэлт; - Байр зүйн дэвсгэр зураг боловсруулах; - Онцгой байдлын дүгнэлт; - Магадлалын ерөнхий дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт/ <u>Зургийн төслийн иж бүрдэл:</u> - Эскиз - Ажлын зураг - ЕТ- Ерөнхий төлөвлөгөө - БА- Барилга архитектур - ТХ- Технологийн зураглал - ББ- Барилга бүтээц /Бүтээцийн тооцооны хамт/ - ХАС- Халаалт, агаар салхивч - ЦБУ- Цэвэр бохир ус - ДГ- Дотор гэрэлтүүлэг - ХТ- Хүчит төхөөрөмж - ХД- Холбоо дохиолол - ГД- Гадна дулаан хангамж - УХАТ- Ус хангамж, ариутгах татуурга

		- ГЦ- Гадна цахилгаан - ГХ- Гадна холбоо дохиолол - Барилгын төсөв Зураг төсөлд тавигдах шаардлага: - Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх; - Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага. а. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх; б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-848 UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх;
7	Зураг, төсөл зохиох үе шат хугацаа	- 1 үе шаттай; - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно;
8	Зураг төслийн байгууллага	- Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж
9	Хөрөнгө оруулагч /захиалагч/ байгууллага	- Эрүүл мэндийн яам;
10	Онцгой нөхцөл	Барилга байгууламж: - Төвийн барилгад хөдөлгөөний урсгалыг оновчтой зөв төлөвлөх; - Газар хөдлөлийн 8 баллд төлөвлөх; - Эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал бага байх; - Сэргээдэх эрчим хүч ашиглах; - Барилгын фасад тухайн орчиндоо өнгө үзэмж нэмэхүйц, загвар, сайн чанарын эмульсэн будаг; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, пандусыг норм дүрмийн дагуу төлөвлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зам,талбай, бариул - Нийтийн болон хэвтэн эмчлүүлэх ариун цэврийн өрөөнд норм дүрмийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан суултуур, тоноглол төлөвлөх; - Хавтгай дээвэртэй төлөвлөх бөгөөд эдэлгээний хугацаа 20 жилээс багагүй унифлекс ЭКП, ЭПП ус тусгаарлах дээврийн хуйлмал материал болон түүнтэй дүйцэхүйц ба илүү эдэлгээтэй материал сонгох; - Цонхыг 3 давхар шиллэгээтэй байхаар төлөвлөж, холбогдох стандартын тайлбарт тусгасан байна; - Хашааны гадна хаалгыг чипээр нээгддэг байдлаар төлөвлөх; Гадна талбай: - Зоонозын өвчин судлалын төвийн ажилчид болон үйлчлүүлэгчид зориулсан амрах тусгай хэрэгцээний ногоон байгууламж, архитектурын болон тохижилтын элементүүд, усан оргилуур, гадна гэрэлтүүлэг - Гадна явган зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж замын хөдөлгөөнтэй уялдуулах; - Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийж гүйцэтгэх; - Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг саадгүй түргэн аврагдах нөхцөлийг бүрдүүлэх; - Гадна пандус, шат, довжоог өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж,

		тайлбарт тусгах, ХБИ зориулсан налуу зам, бариул тусгах - Барилгын орц гарцыг гадна авто замтай болон явган замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх; - Борооны ус зайлуулах байгууламжийг өндөржилттэй уялдуулан норм дүрмийн дагуу төлөвлөх; - Зүлэг услах крант төлөвлөх; Инженерийн шугам сүлжээ: - Эдэлбэр газарт газрын зургийн тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах; - Инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөлийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд буулгалт болон нөхөн сэргээлт, зөөж шилжүүлэх ажлыг зураг төсөвт тусгах; - Нөөц цахилгааны эх үүсвэртэй байх; - Агааржуулалт, салхивчийн нэгдсэн системийг норм нормативын дагуу төлөвлөх; - Халаах хэрэгсэл болон хаалт арматурыг аюулгүй байдал хангахаар хамгаалалттай хаалт төлөвлөх; - Цэвэрлэгээ, үйлчилгээнд тохирсон тосгуур төлөвлөх; - Цэвэр усны гадна худагт галын гидрант төлөвлөх; - Өрөө тус бүрийн хаалган дээр цэнэг хураагууртай ослын гэрэл төлөвлөх; - Ослын гэрэлтүүлгийг орц, гарц, коридорт төлөвлөх; - Тус барилгад розетка /ХТ/ төлөвлөхдөө норм, стандартыг мөрдөх; - Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ, шаардлагыг хангахуйц төлөвлөх; - Хонгил, төв хаалга дээр камер төлөвлөж жижүүрийн постонд нэгдсэн удирдлагатай байхаар төлөвлөх; - Хэрэглээний халуун усны шугам төлөвлөх, халаах хэрэгслийг М-140 маркийн ширмэн радиатор сонгох;
11	Архитектур, орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	Ерөнхий төлөвлөгөө: - Ерөнхий төлөвлөгөөг төвийн барилгатай уялдуулан орчин үеийн шаардлагад нийцсэн байхаар төлөвлөх; - ЗӨСТ-ийн ажилчид болон үйлчлүүлэгчид зориулсан амрах тусгай хэрэгцээний ногоон байгууламж, архитектурын болон тохижилтын элементүүд, усан оргилуур, гадна гэрэлтүүлэг гэх мэт төлөвлөх; - Явган хүний замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах; - Гадна талд дасгалын болон цугларалтын талбай тусгах - Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба шинээр төлөвлөх ногоон байгууламжийг нийтийн эзэмшлийн зам талбайтай уялдуулах; - Авто замыг түргэн тусламжийн болон аврах ангийн авто машин хашаан дотор орж барилгад үйлчлэхэд чөлөөтэй байхаар төлөвлөх ба явган замтай огтлолцохгүй байхаар зурагт тусгах; - Аваарын орц, гарцыг төлөвлөх - Агааржуулалтыг технологийн дагуу төлөвлөх
12	Ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл	-Хууль, тогтоомжууд: - Газрын тухай хууль болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;

	боловсруулахад ашиглах материал	- Барилгын тухай Монгол улсын хууль.; - Эрүүл мэндийн тухай Монгол улсын хууль; Норм, нормативууд: - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/; - Эмнэлгийн барилга /БД31-115-12/ - Орон нутгийн Зоонозын өвчин судлалын төвд тавигдах шаардлага - Олон нийт, иргэний барилгын норм ба дүрэм /БНбД 31-03-03/; - Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага /MNS6392:2013/ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/; - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; - Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-21; - MNSOSHAS18001;2012 Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага - MNS 900:2010 Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт - MNS 6458:2014 Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах, ерөнхий шаардлага - MNS CAC/RCP 39:2011 Нийтээр нь үйлчлэх хоол, үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал - MNS 4946:2005 Хоолны газрын ангилал, зэрэглэл шаардлага - MNS 12,05,05:1991 Ажлын байрны агаарт байж болох цацраг идэвхт бодисын хэмжээ - MNS 12.097:1991, MNS 12.098-97, MNS 12.101-091 Ажлын байрны хүчдэлийн түвшин - MNS 5146:2002 Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга тэлэлт - MNS ГОСТ 5583 Техникийн болон эмнэлгийн зориулалттай хийн байдалтай хүчилтөрөгч. Техникийн шаардлага - MNS 4244:1994 Галын аюулгүй байдал, Техникийн шаардлага - MNS 5566:2005 Аж, ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм. - MNS ISO 13485-98 Эмнэлгийн хэрэгслүүд-NCO 9001стандартыг хэрэглэхэд тавигдах онцлог шаардлагууд - MNS ISO 15189:2015 Эрүүл мэндийн лаборатори-чанар болон чадавхид тавих шаардлага - MNS 6616:2016 Эмнэлэгийн лабораторийн аюулгүй ажиллагаа - MNS 5260:2015 Эрүүл мэндийн технологи, Эмийн санд тавих нийтлэг шаардлага - MNS 5530:2014 Эрүүл мэндийн технологи, Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага - MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл - Бусад холбогдох норм, дүрэм. Төсөл, хөтөлбөрүүд: - Мандалговь хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө 2015-2030 он;

13	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21-02-02/; - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/;
14	Эдийн засгийн тооцоо төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;

БОЛОВСРУУЛСАН: Н.МӨНГӨНЦЭЦЭГ